


“Төрийн үйлчилгээ-Иргэдийн мониторинг” төслийн мониторингийн дүн

Улс төрийн Боловсролын Академи АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр “Төрийн үйлчилгээ-Иргэдийн мониторинг” төслийг УТБА-ын салбар бүхий Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад 2006 оны 06-р сарын 25-наас эхлэн 6 сарын туршид хэрэгжүүлсэн билээ. Тус аймгууд дахь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг байгууллагуудын хүнд суртал, иргэдийг чирэгдүүлэх хандлага, авилгад өртсөн болон авилга өгөхийг шаардсан зэрэг тохиолдол бүрийг утас болон шуудангийн хаягаар мэдээлэл авч ажиглалт-мониторинг хийх нэгтгэсэн дүнг олон нийтэд мэдээлэх, орон нутагт авилга, хүнд суртлын эсрэг хийх тэмцлийн хөрс суурь бий болгоход түлхэц үзүүлэхэд уг үйл ажиллагаа чиглэсэн юм. Төсөл хэрэгжсэн энэхүү хугацаанд нийт 848 мэдээлэл бүртгэгдсэн ба авилга авсан болон авилга өгөхийг шаардсан тухай мэдээлэл нийт мэдээллийн 27.94%-ийг эзэлж байна. Иргэдэд хүнд суртал гаргасан, чирэгдүүлсэн тухай мэдээлэл 68.86%-ийг эзэлж байна. Нийт мэдээллийг нэгтгэн үзэхэд сургууль боловсролын байгууллага, хуулийн байгууллага (шүүх, цагдаа), орон нутгийн удирдлага болон эмнэлгийн байгууллагуудтай холбоотой мэдээлэл хамгийн их хувийг эзэлж байна.



Мэдээлэл ирсэн байдлыг үзэхэд Дархан-Уул, Хөвсгөл, Өвөрхангай аймгуудад сургууль боловсролын байгууллагын талаарх гомдол хамгийн ихээр бүртгэгджээ. Өвөрхангай, Ховд, Дорнод аймгууд дахь эмнэлгийн байгууллагууд иргэдийг хамгийн ихээр чирэгдүүлж байгаа талаар тус аймгийн иргэд төслийн багт мэдээлэл ирүүлсэн байна. Дундговь аймгийн Орон нутгийн удирдлагын талаарх мэдээлэл тус аймгаас ирсэн мэдээллийн 26.31%-ийг эзэлж байна.

Улс төрийн Боловсролын Академи